

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

“Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний жагсаалт” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний жагсаалт”-ыг дор дурдсанаар баталсугай:

- 1/ Санхүүгийн түрээсийн үйлчилгээ;
- 2/ Төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ;
- 3/ Цахим төлбөр тооцооны төлөөлөгчөөр ажиллах үйлчилгээ;
- 4/ Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа;

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 371 дүгээр тогтоолоор нэмсэн./

2. “Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний журам, заавар”-ыг боловсруулж, батлуулахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

3. “Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил үйлчилгээний жагсаалт”-д дурдсан ажил үйлчилгээг 2012 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн эрхлэх болохыг хадгаламж, зээлийн хоршоодод мэдэгдсүгэй.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

